

## **МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2023-2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг баталсан.

Дэлхий нийтийг хамарсан коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахал улс орнуудын эдийн засаг, иргэдийн эрүүл мэндэд үлэмж хохирол учруулсаар байна. Гэсэн хэдий ч улс орнууд цар тахлын эсрэг вакцинжуулалт эхэлсэнтэй холбогдуулан “Шинэ хэвийн байдал”-д дасан зохицох байдлаар хөл хориог сулруулж эхэлснээр эдийн засаг эргэн сэргэж байна. Монгол Улсын Засгийн газраас халдварын эрсдэлийг бууруулах боломжит бүхий л арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлж ирсний дотор зорилтот бүлгийн хүн амыг бүрэн, нийт хүн амын 65.5 хувийг вакцинжуулаад байна.

Үүний үр дүнд 2021 оны эхний хагас жилд эдийн засаг 6.3 хувиар өсөж, 2021 оны жилийн эцэст 6.5 хувь, 2022 онд 5.0 хувьд хүрч цаашид өсөлт тогтворжихоор төсөөлж байна.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийг коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын дараах улс орны эдийн засгийг эрчимтэй сэргээх зорилтыг хангахад чиглүүлж, хөдөлмөр эрхлэлт, бүтээмжийг нэмэгдүүлэх, улмаар эдийн засгийг төрөлжүүлж, дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг тогтворжуулах төсөв, санхүүгийн шинэчлэлийн бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага үүсэж байна. Дээрх эдийн засгийн өсөлт, сэргэлтийн бодлогууд, төсвийн шинэчлэлүүдийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд тусган хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурлын 2021 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар батлагдсан “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хууль”-д заасан эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд өөрчлөлт оруулах шаардлага үүсэж байна.

Иймд дээр дурдсан нөхцөл байдал, үндэслэл шаардлагын дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн боловсрууллаа.

--- оОо ---